

БАТЛАВ:

ХАЛДВАРТ ӨВЧИН СУДЛАЛЫН  
ҮНДЭСНИЙ ТӨВ

ЗАХИРАЛ



Л.БАТТӨР

МАГНАЙ ТРЕЙД ХХК

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



ДАЛТАН-ОЧИР

**Халдварт Өвчин Судлалын Үндэсний Төвд  
авто шатахуун (АИ-92, Дизель түлш) нийлүүлэх гэрээ**

Гэрээний дугаар № ХӨСҮТ/202102009

Улаанбаатар хот

Нэг талаас **ХӨСҮТөв** ( цаашид “захиалагч” гэх ), нөгөө талаас **Магнай трейд ХХК** ( цаашид “нийлүүлэгч” гэх ) дараах зүйлийг харилцан тохиролцож 2021 оны 05 дугаар сарын 05-нд энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
2. Захиалагч нь **ХӨСҮТ-д авто шатахуун (АИ-92, Дизель түлш) нийлүүлэх №ХӨСҮТ/202102009** ( цаашид “бараа” гэх ) **69,905,960 /жаран есөн сая есөн зуун таван мянга есөн зуун жаран /** - төгрөгөөр нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
3. Захиалагч нь барааны нийлүүлэлтийг **69,905,960** төгрөгийн төвлөрсөн төсвийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.
4. Нийлүүлэгч нь **Хавсралтанд заагдсан 2 нэр төрлийн авто шатахуун (АИ-92, Дизель түлш) -ыг 69,905,960 төгрөгөөр** 2021 оны 05 дугаар сарын 05-аас 2022 оны 05 дугаар сарын 04-ны өдрийн дотор нийлүүлж хүлээлгэж өгнө.
5. Дор дурдсан бичиг баримт нь гэрээний хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:
  - a. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
  - b. Бусад шаардлагатай баримт бичиг<sup>1</sup>;
  - c. Тендер ба үнийн хуваарь;
  - d. Гэрээний тусгай нөхцөл;
  - e. Гэрээний ерөнхий нөхцөл;
  - f. Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь;
  - g. Санхүүжилтийн хуваарь.

<sup>1</sup> Хоёр тал харилцан тохиролцож гэрээний нөхцөлд оруулсан зайлшгүй шаардлагатай нэмэлт өөрчлөлтүүд

Гэрээ нь энд дурдсан барааны нийлүүлэлтийн талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хариуцлагыг хүлээж байна.
7. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг хариуцлага хүлээж байна.
8. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.
9. Захиалагч нь гэрээний бусад нөхцөл болзлыг үл өөрчлөн барааны тоо хэмжээг 20 хувиар өсгөх буюу 20 хувиар бууруулах эрхтэй.

#### ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

ХӨСҮТ-ийн Стратеги төлөвлөлт,  
гадаад харилцаа эрхэлсэн дэд  
захирлын үүрэг гүйцэтгэгч  
Д.Баярсайхан

ХӨСҮТ-ийн Санхүүгийн албаны даргын  
албан үүргийг түр орлон гүйцэтгэгч  
Б.Пагамдулам

ХӨСҮТ-ийн ХҮИТ Албаны дарга  
Н.Батням

ТАМГА

ХАЯГ:  
УБ-48 БЗД Нам-Ян-Жүгийн гудамж  
УТАС: 451185

Харилцагч банкны нэр: Төрийн сан  
Дансны дугаар: 100900020010

Регистрийн дугаар: 9077901

#### НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

Магнай трейд ХХК-ийг Худалдаа  
эрхэлсэн дэд захирал  
А.Туул

Борлуулалтын хэлтсийн дарга  
Б.Ууганбаяр

Халамж авлагын менежер  
Ц.Тэргэлэн

ХАЯГ: УБ хот. СБДүүрэг,  
6-р хороо, Нэгдсэн үндэсний гудамж  
МТ байр

УТАС: 78001010, 93001010  
ФАКС: 976-11-350010,

Харилцах банкны нэр:  
Хаан Банк  
Дансны дугаар: 5038060696  
Голомт банк  
Дансны дугаар: 8125100468

Регистрийн дугаар: 2082489